



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/203

Сүхбаатар сум

“Хүний эрхийн төлөө хамтдаа” аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дугаар зүйлийн 19.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, “л”, 39 дүгээр зүйлийн 39.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2020-2023 оны төлөвлөгөө” батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүний эрхийг хангах зорилго бүхий “Хүний эрхийн төлөө хамтдаа” аяныг 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийг дуустал аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. “Хүний эрхийн төлөө хамтдаа” аяны удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Хууль тогтоомж болон удирдамжийн хүрээнд хүний эрхийг дээдэлсэн олон талт ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, идэвх, санаачилгатай ажиллахыг сум, агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

4. Хүний эрхийн төлөө хамтдаа аяныг зохион байгуулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган, дүнг нэгтгэн танилцуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ